



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

2023





Агуулга

- 01 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
- 02 ВХҮҮ–ИЙН АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 03 ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ
- 04 ПРОГРАММ ХАНГАМЖ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ
- 05 МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ
- 06 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
- 07 САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлэл
- Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл
- Хүснэгт 3. ВХҮҮ дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл
- Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч
- Хүснэгт 5. MNS ISO/IEC 27001 стандартын мэдээлэл
- Хүснэгт 6. ВХҮҮ-ийн системийн мэдээлэл
- Хүснэгт 7. ВХҮҮ-ийн МУТСТ хяналтын системийн мэдээлэл
- Хүснэгт 8. МУТСТ эрсдэлийн үнэлгээ
- Хүснэгт 9. ВХҮҮ-ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн мэдээлэл
- Хүснэгт 10. Орлогын дэлгэрэнгүй тайлан \төгрөгөөр\

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Хувьцаа эзэмшлийн бүтэц
- Зураг 2. ТУЗ-ийн гишүүдийн задаргаа
- Зураг 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
- Зураг 4. Гадаад нийт арилжаан дүн
- Зураг 5. Дотоод нийт арилжааны дүн
- Зураг 6. Дотоод болон гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ 2023 \тэрбум төгрөгөөр\
- Зураг 7. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо
- Зураг 8. Нийт харилцагчийн мэдээлэл
- Зураг 9. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал
- Зураг 10. МУТСТ Систем

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|-------|---|
| ВХ | Виртуал хөрөнгө |
| ВХҮҮ | Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч |
| МУТСТ | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх |
| УТНБЭ | Улс төрийн нөлөө бүхий этгээд |

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хураангуй танилцуулга


2023 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд нэр бүхий 12 ВХҮҮ бүртгэлтэй байна. Доорх хүснэгтэд бүртгэлтэй ВХҮҮ-ийн товч мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлэл

| № | Хуулийн этгээдийн нэр | Регистрийн дугаар | Үүсгэн байгуулагдсан огноо | Бүртгэл олгосон огноо | ВХҮҮ-ийн платформын хаяг | Үйл ажиллагааны чиглэлийн тоо |
|----|-------------------------------------|-------------------|----------------------------|-----------------------|--------------------------|-------------------------------|
| 1 | “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК | 6210139 | 2017.08.01 | 2022.09.21 | Trade.mn | 5 |
| 2 | “Койн Хаб” ХХК | 6693326 | 2021.04.06 | 2022.09.21 | Coinhub.mn | 5 |
| 3 | “Айдакс” ХХК | 6803016 | 2021.12.30 | 2022.09.21 | Idax.exchange | 5 |
| 4 | “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | 3645789 | 2021.09.23 | 2022.10.10 | Ncx.mn | 3 |
| 5 | “Корекс” ХХК | 6752586 | 2021.09.07 | 2022.10.10 | Corex.mn | 5 |
| 6 | “Икс Мета” ХХК | 6784771 | 2021.11.18 | 2022.10.10 | X-meta.com | 5 |
| 7 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | 6719791 | 2021.06.20 | 2022.10.10 | Complex.mn | 5 |
| 8 | “Чойжин Алтекс” ХХК | 6785123 | 2021.11.18 | 2022.10.10 | Altex.mn | 5 |
| 9 | “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | 6671845 | 2021.03.04 | 2022.10.10 | Zoos.digital | 5 |
| 10 | “Капекс капитал” ХХК | 6792987 | 2021.12.07 | 2022.11.25 | Capex.mn | 3 |
| 11 | “Анд дэнөүд” ХХК | 6783147 | 2021.11.12 | 2022.11.25 | Denode.io | 5 |
| 12 | “Поверэд Эй Ди Эм” ХХК | 6906834 | 2022.08.25 | 2023.01.13 | Octagon.mn | 5 |

Дээрх нэр бүхий 12 ВХҮҮ-ээс 11 нь Улаанбаатар хотод байршилтай бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байршилтай байна. Түүнчлэн 12 ВХҮҮ-ээс 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан 5 үйлчилгээг үзүүлэхээр Хороонд бүртгүүлсэн бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК болон “Капекс капитал” ХХК нь виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах гэсэн 3 үйлчилгээг үзүүлэхээр бүртгэл хийлгэсэн.

Зураг 1. Хувьцаа эзэмшлийн бүтэц




12 ВХҮҮ нийт 24 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд үүнээс тал хувь нь 50–99% хүртэлх хувийг эзэмшиж байна. Мөн 24 хувьцаа эзэмшигчээс 7 нь хувь хүн, 17 нь хуулийн этгээд ба “Комплекс Дижитал Экосистем” ХХК-ийн 10%-ийг “Bittrex Global GmbH” LLC гэх гадаад хуулийн этгээд эзэмшиж байна.

Зураг 2. ТУЗ-ийн гишүүдийн задаргаа



Зураг 2-оос харахад 12 ВХҮҮ нийт 72 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй бөгөөд 46 нь хараат, 26 нь хараат бус гишүүн байна. Түүнчлэн 7 ВХҮҮ-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь тухайн ВХҮҮ-ийн эцсийн өмчлөгч байна.

Зураг 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ



ВХҮҮ нь дунджаар 2 орчим тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК хамгийн багадаа 1.2 тэрбум, “Чойжин Алтекс” ХХК хамгийн ихдээ 3 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Тус 12 ВХҮҮ нь нийт 24.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн байна.

ВХҮҮ–ийн арилжааны зохион байгуулалт


Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүнгээр задлан харвал:

- ◆ “Айдакс” ХХК – 42.1%
- ◆ “Койн Хаб” ХХК – 33.5%
- ◆ “Икс Мета” ХХК – 19.1%
- ◆ “Дижитал Эксчэйнж Монголиа” ХХК – 2.8%
- ◆ Бусад – 2.5%

2023 оны жилийн эцсийн байдлаар МУ дахь виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 241.9 тэрбум төгрөг, харин өдрийн нийт дундаж арилжаа 150.1 сая төгрөг байна.


Дотоодын виртуал хөрөнгийг арилжаагаар нь авч үзвэл “Ай Дакс” ХХК нийт зах зээлийн 42 хувь, “Койн Хаб” ХХК 33 хувь болон “Икс Мета” ХХК 19 хувийг тус тус эзэлж байна. Нийт дотоод арилжааны 94 хувийг гурван виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүрдүүлж байна.

Зураг 4. Гадаад нийт арилжааны дүн \тэрбум төгрөг\




Хороонд бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан 2023 оны жилийн эцсийн байдлаар гадаадын виртуал хөрөнгө нийт 1.12 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Харин “Поверэд Эй Ди Эм” ХХК болон “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК дээр тус онд гадаад виртуал хөрөнгийн ямар ч арилжаа хийгдээгүй байна.

Зураг 5. Дотоод нийт арилжааны дүн \тэрбум төгрөг\



Харин 2023 оны жилийн эцсийн байдлаар дотоодын виртуал хөрөнгө нийт 136.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. “Чойжин Алтекс” ХХК дээр дотоодын виртуал хөрөнгө арилжаалагддаггүй бөгөөд “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК нь тус онд дотоод виртуал хөрөнгийн ямар ч арилжаа хийгээгүй байна.

Зураг 6. Дотоод болон гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ 2023 \тэрбум төгрөг\




Дотоодын болон гадаадын виртуал хөрөнгийн нийт арилжаа сар бүрээр харуулбал дээрх байдалтай байна. Үүнээс дүгнэхэд 2023 оны 1 сард арилжааны хэмжээ хамгийн өндөр түвшинд байсан бөгөөд 2 дугаар сараас эхлэн арилжааны хэмжээ тогтмол буурсаар 10, 11, 12 дугаар саруудад арилжааны хэмжээ өссөн.

ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоодын виртуал хөрөнгө

Зураг 7. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо

Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр нийт 49 виртуал хөрөнгө бүртгэлтэй байгаагаас “IHC, ARDX” нь хамгийн олон буюу 5 ВХҮҮ дээр, “ZESC” 4 ВХҮҮ дээр, “SPC, ADMC” нь 3 ВХҮҮ дээр, “OBOT, MONT, WPL, MNFT” нь 2 ВХҮҮ дээр арилжаалж байгаа бол үлдсэн нь зөвхөн 1 ВХҮҮ дээр арилжигдаж байна.



Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

| № | Виртуал хөрөнгийн нэр | 2023.01.01–ний өдрийн ханш | 2023.12.31–ний өдрийн ханш | Жилийн ханшийн өөрчлөлт | Зах зээлийн үнэлгээ |
|----|-----------------------|----------------------------|----------------------------|-------------------------|---------------------|
| 1 | A100F | 1 | 2.55 | 155% | 166,236,0246.42 |
| 2 | A40B | – | – | – | – |
| 3 | A44L | 1.01 | 0.9 | -10.89% | 560,096,086.04 |
| 4 | A45J | 0.9 | 1.05 | 16.67% | 745,245,978.3 |
| 5 | A47K | 1.0678 | 1.6999 | 59.2% | 831,216,682.8 |
| 6 | A55I | 1.1201 | 1.7998 | 60.7% | 2,225,323,963.7 |
| 7 | A55M | 1.16 | 1.17 | 0.87% | – |
| 8 | A60C | 1.09 | 1.99 | 82.5% | 4,381,576,186.6 |
| 9 | A66H | 1.0323 | 1.25 | 21.1% | 910,906,722.4 |
| 10 | A70D | 1.1 | 1.65 | 50.03% | 1,075,848,731.4 |
| 11 | A77G | 1.76 | 1.7 | -3.41% | 1,662,442,512.9 |
| 12 | A80E | 1.1792 | 1.501 | 27.3% | 978,521,917.5 |
| 13 | BS9 | 1000 | 1090 | 9% | 15,859,223,772.2 |
| 14 | ADMC | 3.79 | 0.302 | -92.04% | 635,884,943.8 |
| 15 | ARDX | 30.776 | 37.098 | 20.54% | 21,885,983,748.4 |
| 16 | ARDM | 0.035 | 0.0194 | -44.35% | 855,580,409.4 |
| 17 | ARDT | 4700 | 3470.03 | -26.17% | 9,411,189,883.45 |
| 18 | BES | 0.12 | 0.48 | -60.00% | 863,965.98 |
| 19 | BID | 0.16 | 0.38 | 137.50% | 1,761,989,933.20 |
| 20 | CHB | 17.29 | 15.56 | -10.01% | 6,118,083,458.57 |
| 21 | IHC | 0.204 | 0.09 | -55.19% | 14,796,862,613.39 |
| 22 | SPC | 0.137 | 0.2016 | 47.33% | 16,563,978,485.84 |
| 23 | MNFT | 0.05 | 0.041 | -17.59% | 2,782,907,686.57 |
| 24 | MNDT | 1 | 1 | 0.00% | 21,420,697.64 |

| | | | | | |
|----|-------|---------|--------|---------|------------------|
| 25 | EAC | 0.007 | 0.001 | -85.71 | 342,515,384.05 |
| 26 | DAC | 0.086 | 0.033 | -61.63 | 98,977,628.28 |
| 27 | WPL | 0.0386 | 0.06 | 43.13 | 587,994,422.63 |
| 28 | ELFC | 0.0144 | 0.007 | -51.53 | 451,047,656.71 |
| 29 | ICTG | 81 | 61.9 | -23.58 | 7,724,711,562.41 |
| 30 | DC | 0.52 | 0.38 | -26.92 | 211,835,481.93 |
| 31 | ZESC | 0.37275 | 0.348 | -6.64 | 594,051,157.60 |
| 32 | OBOT | 19.23 | 27.71 | 44.10 | 784,435,839.88 |
| 33 | MONT | 1 | 0.995 | -0.50 | 309,501,958.71 |
| 34 | TRD | 0.18 | 0.19 | 5.56 | 3,800,000,000.00 |
| 35 | NTC | 0.472 | 0.173 | -63.35 | 6,374,877,098.00 |
| 36 | CRX | 1.55 | 0.77 | -50.32 | 217,271,291.62 |
| 37 | ZOOS | 0 | 0.55 | 55% | 142,570,883.95 |
| 38 | CPX | 0.03 | 0.01 | -48.00 | 218,230,702.99 |
| 39 | GER | 0.024 | 0.013 | -45.83 | 131,635,122.92 |
| 40 | CARE | 0.008 | 0.005 | -40% | 13,283,388.65 |
| 41 | CAEL | 1.5 | 1.2 | -19.98% | 596,801,504.77 |
| 42 | BDC | 98 | 1 | -98.9% | 2,838,423.48 |
| 43 | CAMEL | 0.041 | 0.4 | 875.6% | 16,811,780,181.6 |
| 44 | MSC | 0.1 | 0.0811 | -18.90 | 260,682,592.18 |
| 45 | MOZO | 0.0552 | 0.02 | -63.77 | 260,682,592.18 |
| 46 | MGLS | 0.011 | 0.011 | 0.00 | 70,129,135.01 |
| 47 | IIT | 0.4445 | 0.1 | -77.50 | 19,538,209.78 |
| 48 | URGX | 0.3497 | 0.2269 | -35.12 | 1,221,344,443.21 |
| 49 | DAXT | 1.01 | 1.15 | 13.86 | 1,281,422,725.50 |

2023 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр арилжаалагдаж буй дотоодын 49 виртуал хөрөнгө дунджаар 10.4 хувийн өсөлттэй байна.

Харилцагчийн мэдээлэл

Тус Хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн харилцагчид давхардсан тоогоор дараах байдалтай байна.

Хүснэгт 3. ВХҮҮ дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл


| № | Хуулийн этгээдийн нэр | Нийт бүртгэлтэй харилцагч | Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч | Нийт идэвхтэй харилцагч |
|-------------|-------------------------------------|---------------------------|---------------------------------------|-------------------------|
| 1 | “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК | 213,453 | 84,268 | 3,004 |
| 2 | “Койн Хаб” ХХК | 189,698 | 118,707 | 3,307 |
| 3 | “Айдакс” ХХК | 161,852 | 43,109 | 3,092 |
| 4 | “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | 13,633 | 4,976 | 104 |
| 5 | “Корэкс” ХХК | 64,898 | 30,405 | 17 |
| 6 | “Икс Мета” ХХК | 70,752 | 32,189 | 4,566 |
| 7 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | 127,125 | 52,925 | 575 |
| 8 | “Чойжин Алтекс” ХХК | 78 | 78 | 12 |
| 9 | “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | 2,233 | 1,183 | 0 |
| 10 | “Капекс капитал” ХХК | 32,847 | 15,973 | 466 |
| 11 | “Анд дэнөүд” ХХК | 1,354 | 186 | 2 |
| 12 | “Поверэд Эй Ди Эм” ХХК | 43,099 | 2,341 | 25 |
| Нийт | | 921,022 | 386,340 | 15,170 |

Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч

| № | Хуулийн этгээдийн нэр | НИЙТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД | | | | |
|----|-------------------------------------|---|-------------------------|-------------------------------------|----------------|-------------------------|
| | | Дотоодын иргэн | Дотоодын хуулийн этгээд | Дотоодын улс төр нөлөө бүхий этгээд | Гадаадын иргэн | Гадаадын хуулийн этгээд |
| 1 | “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК | 84,247 | 5 | 58 | 16 | 0 |
| 2 | “Койн Хаб” ХХК | 118,626 | 10 | 20 | 71 | 0 |
| 3 | “Айдакс” ХХК | 5,445 | 11 | 0 | 37,653 | 0 |
| 4 | “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | 4,963 | 2 | 0 | 11 | 0 |
| 5 | “Корэкс” ХХК | 30,395 | 10 | 0 | 0 | 0 |
| 6 | “Икс Мета” ХХК | 31,713 | 0 | 10 | 476 | 0 |
| 7 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | 52,918 | 7 | 228 | 0 | 0 |
| 8 | “Чойжин Алтекс” ХХК | 75 | 3 | 0 | 0 | 0 |
| 9 | “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | 1,183 | 0 | 0 | 0 | 0 |
| 10 | “Калекс капитал” ХХК | 15,555 | 0 | 0 | 418 | 0 |
| 11 | “Анд дэнүүд” ХХК | 184 | 2 | 0 | 0 | 0 |
| 12 | “Поверэд Эй Ди Эм” ХХК | 2,341 | 0 | 0 | 0 | 0 |

2023 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй виртуал хөрөнгийн үзүүлэгч дээр давхардсан тоогоор нийт 921,022 харилцагч бүртгэлтэй байна. Үүнээс 41.9 хувь буюу 386,340 харилцагч баталгаажуулалт хийсэн байна.

Зураг 8. Нийт харилцагчдын мэдээлэл




Зураг 9. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал




Нийт баталгаажуулалт хийсэн 386,340 харилцагчийг төрлөөр ангилан харвал дотоодын иргэн хамгийн их буюу 347,635 харилцагч байгаа бөгөөд үүний 316 нь улс төрд нөлөө бүхий этгээд байна. Мөн дотоодын 50 хуулийн этгээд, гадаадын 38,659 иргэн тус тус харилцагчийн баталгаажуулалтыг хийсэн байна.

БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД

Насны бүлгээр



Хүйсээр



Баталгаажуулалт хийсэн харилцагчийг нас, хүйсийн байдлаар задлан үзвэл дараах байдлаар харагдаж байна. Насны бүлгээрх ангиллыг харвал 31–45 насны харилцагчид дийлэнх хувийг эзэлж байна. Харин хүйсээр нь авч үзвэл эрэгтэй харилцагчид баталгаажуулалт хийж арилжаанд оролцох нь илүү байгааг харж болно.

Программ хангамж, мэдээлэл технологийн байдал

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “виртуал хөрөнгийн үйлчилгээнд ашиглах мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх” гэж заасны дагуу тус Хороонд бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь MNS ISO/IEC 27001: 2021 Мэдээллийн технологи. Аюулгүй байдлын арга техник, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартын аудитыг хийлгэсэн байна. Энэ олон улсын стандартын зориулалт нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог байгуулах, хэрэгжүүлэх, ашиглах ба тасралтгүй сайжруулах шаардлагад чиглэгддэг.

Хүснэгт 5. MNS ISO/IEC 27001 стандартын мэдээлэл

| Хуулийн этгээдийн нэр | Баталгаажуулсан байгууллага | Огноо | Дугаар |
|-------------------------------------|--|------------|-----------------|
| “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК | АНУ-ын “BQSR Quality Assurance” | 2022.07.20 | BQSR16742 |
| “Койн Хаб” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.07.01 | INT/2206CL/2747 |
| “Айдакс” ХХК | БНЭУ-ын “TNV System Certification” | 2022.08.03 | 220803057601 |
| “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | АБНЕУ-ын “Quality Research Organization” | 2022.08.25 | 305022092624IS |
| “Корэкс” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.08.27 | INT/2208CL/3068 |
| “Икс Мета” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.08.23 | INT/2208XE/3035 |
| “Комплекс Дижитал Экосистем” ХХК | БНЭУ-ын “BQSR quality assurance PVT” LTD | 2022.08.20 | BSQR17502 |
| “Чойжин Алтекс” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.09.12 | INT/2209CL/3143 |
| “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.08.27 | INT/2208ZI/3069 |
| “Капекс капитал” ХХК | АНУ-ын “BQSR Quality Assurance” | 2022.09.16 | BQSR18106 |
| “Анд дэнүүд” ХХК | БНЭУ-ын “QFS Management Systems” | 2022.09.08 | INT/2208AE/3036 |
| “Поверэд Эй Ди Эм” ХХК | БНЭУ-ын “QFS Certification Limited” | 2022.08.29 | 220915057601 |

Зураг 10. МУТСТ Систем

| | | |
|---|----|--|
| Дотооддоо хөгжүүлэлт хийж байгаа | 2 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК болон “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК нь дотооддоо мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх автомат хяналтын системийг хөгжүүлж байгаа бол бусад ВХҮҮ нь гадаад болон дотоодын системийг хослуулан хэрэглэх байдлаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байна. |
| Олон улсын хяналтын систем ашиглаж байгаа | 10 | |

Тус 12 ВХҮҮ–ийн үйл ажиллагаанд ашиглаж буй үндсэн, туслах, мэдээлэл хадгалах, харилцагчийн үйлчилгээний болон хэтэвчний үйлчилгээний системүүдийг тус тус задлан харвал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6. ВХҮҮ–ийн системийн мэдээлэл

| № | Хуулийн этгээдийн нэр | Үндсэн систем | Туслах систем | Мэдээлэл хадгалах систем | Харилцагчийн үйлчилгээний систем | Хэтэвчний үйлчилгээний систем |
|---|-------------------------------------|--|--|--|---|---|
| 1 | “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК | Олон улсны стандартад нийцүүлэн Монгол инженерүүдийн ур чадвараар 2017 оноос хойш хөгжүүлсэн Койн банк нэртэй өөрсдийн цогц системийг ашиглаж байна. | | | | |
| 2 | “Койн Хаб” ХХК | ByteTrade компанийн хөгжүүлсэн арилжааны систем ашигладаг. | OKX олон улсын ВХҮҮ–ийн USDT хослолуудын арилжааг liquidity provider зорилгоор API ашиглан холбосон. | AWS платформын аюулгүй сервер, датабаазыг ашигладаг. | Олон улсын Zendesk харилцагчийн үйлчилгээний платформ ашигладаг. | Олон улсын Fireblocks хэтэвчний менежментийн систем ашигладаг. |
| 3 | “Айдакс” ХХК | “CHAINUP PTE” Ltd–аас худалдан авч ашигладаг программ хангамжаар дамжуулан үйлчилгээ үзүүлдэг байна. | Банкнүүдын холболт, үүрэн операторуудын холболт болон мэйлтэй холбогдсон холболт зэргээс бүрдэнэ. | Amazon Web Service (AWS) дээр мэдээллээ хадгалдаг. | | MPC(Multi party computation) төрлийн хэтэвчийг хөгжүүлэн хэрэглэгчдийн хөрөнгийг хадгалж байна. |
| 4 | “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | Бүгд Найрамдах Солонгос Улсад бүртгэлтэй “Полак” ХХК /Polax/–ийн системийг ашигладаг.Hollaex–kit 2.9.3 | Amazon EC2 | Site5 виртуал сервер | Amazon AWS | Cold болон Hot wallet нь Hollaex төв серверт байрладаг бөгөөд нууцлал, хамгаалалтын өндөр түвшинтэй |
| 5 | “Корэкс” ХХК | Олон улсын нээлттэй API стандартын дагуу өөрсдөө зохиож хөгжүүлсэн. | | Google cloud дата төвд хадгалдаг. | Олон улсын нээлттэй API стандартын дагуу өөрсдөө зохиож хөгжүүлсэн. | |
| 6 | “Икс Мета” ХХК | Байнанын үндсэн систем дээр тулгуурлан ажилладаг болно. | | | | (Binance Hot Wallet) ситемийг ашигладаг. |

| | | | | | | |
|----|----------------------------------|---|---|----------------------------------|---|---|
| 7 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | Олон улсын нээлттэй API стандартын дагуу өөрсдөө зохиож хөгжүүлсэн систем. | – Amazon AWS – Cloudfare – Google cloud | MongoDB | Дотоодын систем / өөрийн хөгжүүлэлт/, Callpro | Complex wallet management system / өөрийн хөгжүүлэлт/, OKX.com wallet management system |
| 8 | “Чойжин Алтекс” ХХК | Олон улсын BTSE компанийн өөрсдийн хөгжүүлсэн технологийг ашигладаг. | | | | |
| 9 | “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | Олон улсын нээлттэй API стандартын дагуу өөрсдөө зохиож хөгжүүлсэн системийг ашигладаг. | | MongoDB | Олон улсын нээлттэй API стандартын дагуу өөрсдөө зохиож хөгжүүлсэн системийг ашигладаг. | |
| 10 | “Капекс капитал” ХХК | Modulus биржийн системийг ашигладаг. | | | | |
| 11 | “Анд дэнүүд” ХХК | Дотооддоо хөгжүүлсэн систем OKX болон GTN систем | | | CallPro систем | – Дотооддоо хөгжүүлсэн систем – OKX болон GTN систем |
| 12 | “Поверэд Эй Ди Эм” ХХК | Whitelabel– ийн AWS RDS системийг ашигладаг. | Mongo atlas | AWS RDS, S3 системийг ашигладаг. | Өөрсдийн хөгжүүлсэн chainstack private node системийг ашигладаг. | Fireblock систем |

ВХҮҮ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх бөгөөд тус 12 ВХҮҮ олон улсад хөгжүүлэгдсэн системийн эрхийг худалдан авч хэрэглэж байна.


Хүснэгт 7. ВХҮҮ–ийн МУТСТ хяналтын системийн мэдээлэл

| № | Хуулийн этгээдийн нэр | МУТСТ хяналтын системийн нэр | Хэрэглээний зорилго, тайлбар |
|---|---------------------------------|------------------------------|--|
| 1 | “Дижитал Эксчэйнж Монголиа” ХХК | TRMLabs систем | – Монгол Улсын хэрэглэгчдийг таних – Гадаад улсын хэрэглэгчдийг таних – Арилжаа, түрийвчний гүйлгээг мөшгөх, үлдэгдэл харах болон хяналт тавих |
| 2 | “Койн Хаб” ХХК | Crystal систем | – Гүйлгээг таньж мэдэх. Сэжигтэй гүйлгээний 200,000 тохиолдлыг дохио өгөх байдлаар сануулсан – Гадаад улсаас бүртгүүлж буй хэрэглэгчийн мэдээллийг шалгах бөгөөд МУТСТ хяналтыг хэрэгжүүлэх, хуурамч хаягийг илрүүлэх – Монгол Улсын иргэнийг улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг шалгах |
| 3 | “Айдакс” ХХК | Сумсаб /Sumsab/ систем | – Харилцагчийг таньж мэдэх eKYC–ийг хэрэгжүүлэх |

| | | | |
|----|-------------------------------------|--|--|
| 4 | “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | – “Полак” систем | – Харилцагчийг таньж мэдэх eKYC-ийг хэрэгжүүлэх |
| 5 | “Корэкс” ХХК | – ДАН систем – Elliptic систем – Монпэп систем | – Монгол Улсын хэрэглэгчдийг таних – Гүйлгээг таньж мэдэх, хяналт тавих – Монгол Улсын иргэнийг улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг шалгах |
| 6 | “Икс Мета” ХХК | – Chainanalysis систем – Jumio систем | – Монгол Улсын хэрэглэгчдийг таних – Гүйлгээг таньж мэдэх, хяналт тавих – Монгол Улсын иргэнийг улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг шалгах |
| 7 | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | – Дотооддоо систем хөгжүүлсэн | |
| 8 | “Чойжин Алтекс” ХХК | – BTSE нь Coinfirm систем | – Харилцагчийг таньж мэдэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах – Сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд программ автоматаар зогсож, мэдэгдэх |
| 9 | “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК | – Дотооддоо систем хөгжүүлсэн | |
| 10 | “Капекс капитал” ХХК | – Modulus систем | – Гүйлгээг таньж мэдэх. Сэжигтэй гүйлгээний 200,000 тохиолдлыг дохио өгөх байдлаар сануулсан – Хэрэглэгчдийн хар жагсаалт болон их дүнтэй арилжаанд хяналт тавих – Харилцагчийг таньж мэдэх eKYC-ийг хэрэгжүүлэх |
| 11 | “Анд дэнөүд” ХХК | – Elliptic систем – | – Хэрэглэгчийг таньж мэдэх – Гүйлгээг таньж мэдэх |
| 12 | “Поверэд Эй Ди Эм” ХХК | – Fireblocks систем – Chainalysis систем | – Монгол Улсын хэрэглэгчдийг таних – Арилжаа, түрийвчний гүйлгээг мөшгөх, үлдэгдэл харах болон хяналт тавих |

“Комплекс Дижитал Экосистем” ХХК болон “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК нь дотооддоо мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх автомат хяналтын системийг хөгжүүлж байгаа бол бусад ВХҮҮ нь гадаад болон дотоодын системийг хослуулан хэрэглэх байдлаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байна

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл



Хорооны 2023 оны жилийн эцсийн байдлаар хийсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 12 ВХҮҮ-ийн төрлөх эрсдэл дундаж, бизнесийн болон бүтцийн эрсдэл мөн адил өндөр байна. Мөн тус байгууллагуудыг үйл ажиллагааны зорилго, идэвхтэй байдал, арилжааны хэмжээ, харилцагчдын тоо, байгууллагын хэмжээ зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үнэлсэн болно.

Хүснэгт 8. МУТСТ эрсдэлийн үнэлгээ

| ЭРСДЭЛ БАГА | ЭРСДЭЛ ДУНДАЖААС ДООШ | ЭРСДЭЛ ДУНДАЖ | ЭРСДЭЛ ДУНДЖААС ДЭЭШ | ЭРСДЭЛ ӨНДӨР |
|-------------------------------------|-----------------------|----------------------------------|----------------------|---------------------------------|
| “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК | “Айдакс” ХХК | “Корэкс” ХХК | – | “Дижитал Эксчейнж Монголиа” ХХК |
| “Зоос Дижитал Эксчейнж” ХХК | “Чойжин Алтекс” ХХК | “Икс Мета” ХХК | – | “Койн Хаб” ХХК |
| “Капекс капитал” ХХК | – | “Комплекс Дижитал Экосистем” ХХК | – | – |
| “Анд дэнөүд” ХХК | – | – | – | – |
| “Поверэд Эй Ди Эм” ХХК | – | – | – | – |

Хорооноос нийт зохицуулалтын салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд хагас жил тутам мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлж, эрсдэлийн хувийн хэрэг үүсгэн ажиллаж байна. Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу бүртгэлтэй ВХҮҮ-ийн эрсдэлийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ын дагуу үнэлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар хийсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 12 ВХҮҮ-ээс 5 нь бага эрсдэлтэй, 2 нь эрсдэл дунджаас доош, 3 нь дундаж, 2 нь эрсдэл өндөр буюу салбарын оролцогчдын 58% буюу 7 ВХҮҮ нь цаашид эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тус 7 ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээг байгууллагын хэмжээ, арилжааны дүн, арилжаанд оролцогчдын төрөл зэрэг хүчин зүйлс нэмэгдүүлж байгаа буюу бизнесийн болон бүтцийн эрсдэл өндөртэй байна.

ВХҮҮ–ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл шаардлагыг тогтоох журам”-ын дагуу Хороонд 2023 оны жилийн эцсийн байдлаар 6 хуулийн этгээд ВХҮҮ–ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдээр бүртгэлтэй байна.

Хүснэгт 9. ВХҮҮ–ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн мэдээлэл

| № | Хуулийн этгээдийн нэр | Регистрийн дугаар | Үүсгэн байгуулагдсан огноо | Бүртгэл олгосон огноо |
|---|---|-------------------|----------------------------|-----------------------|
| 1 | “Монголын үндэсний тайлагнал аудит” ХХК | 6260497 | 2017.12.21 | 2023.02.08 |
| 2 | “Интер Аудит” ХХК | 2712113 | 2022.06.05 | 2023.02.08 |
| 3 | “Шинэ их тэрбум аудит” ХХК | 6000797 | 2015.09.08 | 2023.03.31 |
| 4 | “Өлзийт экаунт аудит” ХХК | 5490677 | 2011.06.20 | 2023.06.02 |
| 5 | “Хүлэгт хүннү аудит” ХХК | 5603889 | 2012.05.23 | 2023.10.25 |
| 6 | “Шонхор үнэлгээ аудит” ХХК | 5821975 | 2014.03.27 | 2023.10.25 |



ВХҮҮ–ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт хөрөнгийн дүн 55.1 тэрбум төгрөг бөгөөд үүнээс эргэлтийн хөрөнгө 34.5 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 20.6 тэрбум төгрөг

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн 55.1 тэрбум төгрөг бөгөөд үүнээс өр төлбөрийн дүн 31.9 тэрбум төгрөг, эздийн өмчийн дүн 23.2 тэрбум төгрөг байна.

НИЙТ ХӨРӨНГӨ ХУВИАР



ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ХУВИАР



Хүснэгт 10. Орлогын дэлгэрэнгүй тайлан \төгрөгөөр\

| № | Үзүүлэлт | 2023.12.31–ний байдлаар |
|---|------------------------------------|-------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 3,919,312,048.66 |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,575,189,606.00 |
| 3 | Нийт ашиг | 2,224,527,637.76 |
| 4 | Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал) | (10,916,885,877.62) |
| 5 | Орлогын дүн | 5,369,770,634.52 |

Харин бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2023 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт орлогын дүн 5.4 тэрбум төгрөг, нийт зардал 12.5 тэрбум төгрөг байна. Мөн 2023 онд дээрх 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийтдээ 10.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй онцлох арга хэмжээ



Хууль, эрх зүйн зохицуулалт

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 253 дугаар тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж баталсан. Тус журмыг Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны веб хуудсанд байршуулж, олон нийтийн хүртээл болголоо.
- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 59 дүгээр тушаалаар төрийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Монголбанк, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын биржүүдийн нэгдсэн холбоо, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг төрийн болон хувийн байгууллагуудаас виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох мэдээ, мэдээллийг авч, дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ, тайлан дүгнэлт боловсруулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо нь ВХҮҮ-ийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн хөгжүүлсэн API системээр дамжуулан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр бодит цагийн горимоор хүлээн авах тогтолцоог бүрдүүлсэн.



Хурал, семинар, уулзалт

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль, эрх зүйн орчин шинээр бүрдсэнтэй холбогдуулан үүсэж болох эрсдэлийг бууруулах, зохицуулалтын ойлгомжгүй байдлыг шийдвэрлэх, бий болох сорилтуудыг даван туулах, тулгамдаж буй асуудлуудын талаар “Монголын Биржүүдийн Нэгдсэн Холбоо” ГҮТББ, “Монголын банкны холбоо” ГҮТББ, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкны комплайнсын ажилтнууд, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал үйлчилгээ үзүүлэгчдийн удирдлага, холбогдох ажилтнуудтай уулзаж санал солилцлоо.



Гадаад хамтын ажиллагаа

- Санхүүгийн зохицуулах хороо “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдал, дотоод хяналт, МУТСТ шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргалаа.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХЭЛТЭС



Засгийн газрын 4 байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-261674



www.frc.mn



vaspd@frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia